

ӨРХИЙН ОРЛОГО БА ХЭРЭГЛЭЭ

Д. Намжил, МУИС, ЭЗС, Санхүүгийн
тэнхмийн багш док /PhD/.

С. Өтөбай, докторант

Улс орны хөгжлийг тодорхойлогч нэг гол үзүүлэлт нь эдийн засгийн өсөлт буюу дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт юм. Харин эдийн засгийн өсөлтийн нэгээхэн хэсэг нь өрхийн хэрэглээ, орлого, зарлага болж байдаг. Хүний хэрэглээ хязгааргүй боловч, түүнийг хангаж буй баялаг хязгаарлагдмал билээ. Тийм ч учраас хүн хүссэнээрээ хэрэглэж, өөрсдийн хэрэглээний сэтгэл ханамжийг хамгийн өндөр байлгах боломжгүй юм. Хэрэглээний зах зээлийн нэг гол зорилго бол хувь хүн, өрхийн хэрэглээ, хүсэл сонирхлыг судлах явдал билээ. Зах зээлийн харилцаанд шилжин орсон 10 гаруй жилийн хугацаанд өрхийн орлогод гарсан гол өөрчлөлт нь хүн амын дийлэнхийн худалдан авах чадвар буурч байгаа явдал юм. Хэрэглэгчийн худалдан авах чадвар нь орлоготой нягт холбоотой байдаг. Орлогын доогуур түвшин нь хямдхан, чанаргүй бараа бүтээгдэхүүн хэрэглэх хандлага бий болгодог. Энэхүү судалгаагаар өрхийн хэрэглээг тодорхойлон өрхийн орлого болон хэрэглээний зохистой харьцааг судлан тогтоож, үнэлэлт дүгнэлт өгсөн.

1. Өрхийн хэрэглээг тодорхойлох нь

Зах зээлийн харилцаанд шилжин орсон 10 гаруй жилийн хугацаанд өрхийн орлогод гарсан гол өөрчлөлт нь хүн амын дийлэнхийн худалдан авах чадвар буурч байгаа явдал юм. Аливаа улс орны хувьд макро эдийн засгийн бодлого зөв явагдаж байвал өрхийн орлогын түвшин буурах биш тогтмол өсөж байх зүй тогтолтой бөгөөд энэ нь эсрэг байдлаар илэрч байгаагийн шалтгаан юу вэ?

Өрхийн орлого бага байгаа тохиолдолд бараа, бүтээгдэхүүнийг сонгох ямарч боломжгүй, хамгийн хямд үнэтэйг шууд худалдан авна. Өрхийн болон хэрэглэгчдийн орлогын түвшин дээшлэх тутам чанар муу, үнэ багатай барааг худалдан авдаггүй. Өрхийн орлогын түвшинг хэрэглээтэй харьцуулан судалдаг. Хэрэглээ орлого нь шууд хамааралтай бөгөөд орлогын өсөлтөөс хэрэглээ хамааралтай. Өрхийн орлого нь цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжээс хамаардаг. Өрх болон хэрэглэгч нь тухайн хугацаанд олсон орлогоо бүгдийг хэрэглээнд зарцуулдаггүй бөгөөд тодорхой хэсгийг хуримтлуулах, хадгаламжинд зориулж байдаг. Иймд орлогын өсөлт нь хэрэглээний өсөлтөөс хоцорч байх зүй тогтолтой. Энэ хоёрын зөрүү нь хадгаламжинд орж байх ёстой. Өрх гэр бүл хэрэглэгч нь тодорхой хугацааны дараа хадгаламжийг хэрэглээнд зарцуулах шаардлага гарна. Энэ үед хэрэглээ нь орлогод ойртох буюу тэнцэх явдал гарна. Гэвч энэ нь түр зуурын шинжтэй байна.


Хөгжиж буй орнуудын хувьд өрхийн болон хэрэглэгчийн хэрэглээг хангах минимум буюу дундаж түвшний үзүүлэлтийг тодорхойлох замаар

хүн амын хэрэглээний байдлыг судалж үзэх шаардлагатай. Хүн ам, өрхийн хэрэглээний байдлыг дээрх үзүүлэлтээр тооцон зохистой болон зохистой бус хэрэглээг тооцон гаргадаг.

Эдийн засгийн тогтвортой өсөлттэй, хүн амын амьжиргааны түвшин тогтмол дээшилж буй улс орнуудын хувьд хүн амын, өрхийн хувьд зохистой хэрэглээг хангаж байдаг.

Зохистой хэрэглээний байдлыг графикаар илэрхийлбэл дараах байдалтай байна.

Зураг 1: Орлого хэрэглээний зохистой харьцаа



Зураг А-д хүн ам, өрхийн орлого нь ямагт хэрэглээнээс илүү өндөр өсөлттэй байж энэ хочрын зөрүүгээр хадгаламж хуримтлалын хэмжээг илэрхийлж харуулсан байна. C – хадгаламж хуримтлалыг илэрхийлнэ.

Зураг Б-д хүн ам, өрхийн дундаж хэрэглээтэй харьцуулахад нийгмийн гишүүдийн орлогын ялгаанаас хамаарч хадгаламж хуримтлал / C, C_1 / янз бүр байгааг илэрхийлж байна. Зохистой хэрэглээний график дүрслэлээс үзэхэд хүн ам, өрхийн орлого нь тогтмол өсөж, нийгмийн гишүүдийн дунд орлогын ялгаа байгаа боловч энэ нь ямагт хэрэглээний дундаж түвшинг хангаж тодорхой хэмжээний хуримтлал бий болгож байгаа нь амьжиргааны түвшин буурахаас найдвартай хамгаалагдах боломж олгож байна.

Зохистой хэрэглээний графикаас мөн улс орны явуулж байгаа төр, засгийн газрын макро эдийн засгийн бодлого шийдвэр зөв байгааг баталж харуулдаг. Төр, засгаас явуулж буй макро эдийн засгийн бодлого нь доголдож, хүн амын болон өрхийн орлого буурч, амьжиргааны өртөг загвар байнга өссөнөөр зохистой бус хэрэглээг бий болгоно. Зохистой бус хэрэглээний зургийн дүрслэлийг харуулбал;



Зохистой бус хэрэглээний үед хүн амын болон өрхийн дундаж орлого нь дундаж хэрэглээнээс доогуур түвшинд байгаа нь дээрх графикаас харагдаж байна. Зохистой бус хэрэглээ нь нийгмийн гишүүдийн орлогын ялгаанаас хамаарч хүн амын дийлэнх хэсэг, өрх, гэр бүл нь дундаж хэрэглээг хангах орлогогүйгээс болж хэрэглээний минимум шаардлагыг хангаж чадахгүйд хүрч байна. Дундаж хэрэглээг хангах хэмжээнд хүрэхийн тулд орлогын дутуу хэсгийг /D-г хангах/ өөр арга хэлбэрээр нөхөхөд зайлшгүй хүргэнэ. D хэсгийг нөхөх арга замыг тодорхойлбол нийгмийн гишүүдийн зүгээс өр, зээл, хээл хахууль, хууль бус бусад арга замыг идэвхтэй ашиглахад хүрнэ.

Өөрийн улс орны иргэд, хүн амыг удаан хугацаанд ийм шударга бус байдалд байлгахыг үл хүсвэл төр, засгаас дорвитой арга хэмжээ авч, зохистой хэрэглээг хангах хэмжээнд хүргэх тууштай бодлого явуулах хэрэгтэй.

Үүний тулд: өрх гэрийн орлого, хуримтлалыг эрс бууруулж, ядууралд хүргэдэг гол үзүүлэлт болох инфляцийн хэт өсөлтөөс хамгаалах, валютын ханшийг тогтвортой байлгах үнэ, цалингийн өсөлтийн зохистой харьцааг алдагдуулахгүй байх арга хэмжээг авч явуулах нь тэргүүн ээлжийн арга хэмжээ болно.

2. Өрхийн орлого, хэрэглээний зохистой харилцааг тогтоох асуудал

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд Засгийн газраас санхүү, мөнгөний бодлогын хүрээнд үнэ чөлөөлж, чөлөөт ханшны тогтолцоог мөрдсөнөөр нийт эдийн засагт зарим нэг нааштай өөрчлөлт гарсан боловч макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд эерэг үр дүн авчирсангүй. Тухайлбал,

1. Мөнгөний /төгрөгийн/ ханшны уналт үргэлжилсэн
2. Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийн байнгын өсөлт
3. Төлбөрийн балансын алдагдал өссөн
4. Хүн амын орлогын ялгаа эрс нэмэгдсэн
5. Өрхийн амьжиргааны түвшин тасралтгүй буурсан зэргээг тодорхойлж болно.

Засгийн газар макро түвшинд авч явуулсан эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлт нь тухайлбал суурь үнэ болох эрчим хүчний, нефтийн үнэ тарифийн болон тээвэр, холбоо, худалдаа, үйлчилгээний үнийн өсөлт нь хүн амын дунд ялангуяа нийт эдийн засагт үр дүнтэй эрэлтийг бүрдүүлж чадсангүй.

Засгийн газраас үе шаттайгаар нэрлэсэн цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлж байгаа боловч энэ нь байнга өсөж байгаа үнийн өсөлтийг нөхөж чадахгүйгээс бодит цалин, хөлс тасралтгүй буурч өрхийн дунд төлбөрийн чадваргүй эрэлт нэмэгдэх үндсэн шалтгаан хэвээр байна.

Аливаа улс орны төр, засгийн газрын үйл ажиллагааг сонгогчдоос үнэлэх гол шалгуур үзүүлэлтийн нэг нь өрхийн орлогын тогтвортой өсөлт юм. Энэ нь тухайн орны нэг хүнд оногдох хадгаламж, хуримтлалын хэмжээгээр тодорхойлогддог. Хэрэв өрхийн сарын дундаж хэрэглээ нь өрхийн дундаж орлого, хадгаламж, хуримтлалаас шууд хамааралтай гэж үзвэл дараах илэрхийлэл бичих боломжтой.

$$\begin{array}{ll} C = F(Y, S) & 1 \\ C = Y + S & 2 \\ Y = C - S & 3 \\ Y > S & 4 \end{array}$$

Аливаа улсын эдийн засгийн бүтцэд онцгой үүрэг гүйцэтгэдэг өрхийн хэрэглээ, орлого, хуримтлалын харьцааг урт удаан хугацаанд дээрх нөхцөл хэрхэн хангагдсан байдлыг авч үзэх хэрэгтэй юм. Тухайн улсын хувьд макро түвшинд эдийн засгийн өсөлттэй, цалин хөлс нэмэгдэх хандлагатай байсан ч микро түвшинд амьжиргааны өртөг өндөртэй хүн ам нь түүнийг нөхөх нөөц хомс байгаа үед нийт эдийн засагт бодит үнэлгээ өгөхөд бэрхшэлтэй болно.

Манай улсын 2003 оны 1-р улиралд ҮСГазраас¹ гаргасан статистик мэдээлэлд Улаанбаатар хотын өрхийн сарын орлого 173 мянга, зарлага нь 206 мянга гэсэн тоо баримтыг дээрх томъёололд оруулбал дараах дүр зураг гарсан байна.

$$\begin{array}{ll} C > Y & 1 \\ S = K & 2 \\ C = Y + S & 3 \\ C = Y + O & 4 \end{array}$$

Зөвхөн нийслэл хотын 300 мянган өрхийн хувьд авч үзвэл дээрх судалгааны тоо баримтаас үзэхэд сарын хэрэглээг хангаад орлогоос хадгаламжаа арвижуулах нөхцөлгүй байгаа нь тодорхой юм. Дотоодод өрх, гэрийн хүрээнд хадгаламж, хуримтлал өгөх үндэслэл дээрх тоо баримтаас үзэхэд бага байгаа боловч улсын хэмжээнд иргэдийн банкинд хадгалуулсан хадгаламж 2002 онд 236 тэрбум болж 2003 оны эхний 10 сарын байдлаар 328 тэрбумд хүрсэн нь эдийн засагчдийн анхааралыг татаж байна. Манай улсын нийт хүн амд бага хувийг¹ эзэлж буй хүмүүсийн хадгаламж өсөж байгаа боловч гаднаас орж ирж буй валютаар дийлэнх өсөлтийг хангасан гэж судлаачид² үзэж байна.

Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин, хөлсийг 2000 оноос ээлж дараалалтай 2003 оны 10 сар хүртэл 63%-иар нэмэгдүүлээд байна. Гэвч цалингийн өсөлт нь бараа бүтээгдэхүүний үнэ, хэрэглээний

дундаж түвшингийн өсөлтөөс хоцорч байгаа тул нэг өрхийн орлого нь зарлагаас 33 мянган төгрөгөөр дутагдах шалтгаан болжээ.

Хүснэгт 1. 2004 оны Улсын төсвийн төсөлд тусгагдсанаар


1. Цалин, хөдөлмөрийн хөлс Үүнээс:	366,0 ³
➤ Төрийн албанд ажиллагсдын цалин, хөдөлмөрийн хөлс /тэрбум/	128,9
➤ Төрийн албанд ажиллагсдын тоо /мянган хүн/	125,8
➤ Нэг ажилтанд оногдох цалин, хөдөлмөрийн хөлс /сар, мянга/	100,0
2. Нийт ажиллагсдын тоо /мянган хүн/	870,0 ⁴
2.1 Нэг ажилтанд оногдох дундаж цалин, хөдөлмөрийн хөлс /сар, мянган төг/	35,0
3. Нийт тэтгэвэр, тэтгэмжинд хамрагдагсдын тоо /мян хүн/	600,0
4. Нийт тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ /тэрбум төг/	148,3 ⁵

Эх сурвалж: “Үнэн” сонин, 2003 оны 11-р сарын 20-ны дугаар

2003 оны 10 сараас дотоод зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний үнэ 15-20 хувиар нэмэгдсэн нь хүнсний гол нэр төрлийн бараа болон үйлчилгээний үнэ тариф өсөхөд хүрээд байна. Энэ нь 2004 онд төрийн албаны ажилтан, албан хаагчдын цалинг дунджаар 25 – 35 хувиар нэмэгдүүлж, хүн ам, өрхийн бодит орлого өсөхөд сөрөг нөлөөлөх нэг шалтгаан болно.

Манай зарим эрдэмтэд, эдийн засагчдын хийсэн судалгаагаар бараа үйлчилгээний үнэ тогтмол өсөж байхад хүн амын хэрэглээний тоо хэмжээ буурахгүй байгаа нь тогтоогджээ.⁶ Энэ нь сонгодог эдийн засагчдын “Үнэ өсөхөд эрэлт буурдаг” эрэлтийн үндсэн хууль Монголд үйлчлэхгүй гэсэн үг юм. Үнийн өсөлтөөс эрэлтийн мэдрэмж хэрхэн хамаарч байгааг графикаар илэрхийлбэл;


Зураг 1. Үнийн өсөлт, эрэлтийн харьцаа



Хүн ам, өрхийн гол нэрийн бараа, үйлчилгээний үнэ тарифын өсөлт нь эрэлтэнд нөлөө үзүүлэхгүй байгааг шилжилтийн үеийн онцлог гэхээс төр засгаас хэрэглээний сагсанд онцгой хувийг эзэлдэг бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэнд тавих хяналт суларсантай холбоотой гэж үзэх үндэслэлтэй. Энэ нь хүн ам, өрхийн амьжиргааны өртгийг

нэмэгдүүлж цаашид орлогын ялгаа, ядуурлын түвшинг ихэсгэж байгаа юм. Хүн ам өрхийн гол нэр төрлийн бараа, үйлчилгээний үнийн өсөлт, эрэлтийн мэдрэмжийг дараах зургаар үзүүлбэл:

Зураг 2. Үнийн өсөлт, эрэлтийн мэдрэмж



Хүн ам, өрхийн сарын хэрэглээнд зайлшгүй чухал хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тарифын өсөлт нь дараах үр дагаварт хүрэхэд нөлөөлж болзошгүй юм.

Нэгдүгээрт. Хүн амын олон нэмэгдэх дундаж хэрэглээг бууруулахад зайлшгүй хүргэнэ.

Хоёрдугаарт. Хүн ам, өрхийн хадгаламж, хуримтлал олоход саад болно.

Гуравдугаарт. Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн хэмжээ буурахад шууд нөлөөлнө.

Үнэ, тарифын өсөлт гарч буй бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлбол юуны өмнө эрчим хүч, дулаан, уур ус, бензин шатахуун, орон сууц, сургалтын төлбөр, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болон мах, сүү, гурил будаа, элсэн чихэр, бусад зүйлс багтана. Эдгээрийн үйлдвэрийн буюу салбараар нь авч үзвэл:

1. Петровис, Алтжин, НИК
2. Төмөр зам, МИАТ
3. Мобиком, Цахилгаан холбоо ХК
4. АПУ, Спирт Бал Бурам
5. Алтан тариа гэх мэт байгууллагуудыг нэрлэж болно.

Монополь байгууллагуудын үйл ажиллагаа нь зах зээл дээрх чөлөөт өрсөлдөөнийг хаан боогдуулж улмаар үнэ тариф буурах, хүн ам, өрхийн орлогын өсөлтөнд муугаар нөлөөлж байгаа нь Монголын эдийн засгийн нэг томоохон бэрхшээл болоод байна. Энэ нь юуны өмнө хүн ам, өрхийн амьжиргааны дундаж өртөг нь орлогын өсөлтөөс түрүүлэх, хэрэглээний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг алдагдуулах, улмаар хөрөнгө оруулалтын өсөлтийг саатуулах хүчин зүйл болж байна.

Хүн ам, өрхийн орлогыг нэмэгдүүлж хэрэглээний түвшинд хүртэл өсгөх талаар төр засгаас зохицуулалтын шинж чанартай арга хэмжээг авч явуулах шаардлагатай юм.

Нэг өрхийн сарын дундаж хэрэглээ нь өнөөдөр 200 мян төгрөг байгаа тул цаашид энэ түвшинг тогтвортой байлгахын тулд үнэ тарифын өсөлтөнд тавигдах төрийн хяналтыг сайжруулах, өрхийн орлого нэмэгдүүлэх ажилчдын тоог нэмэгдүүлэх, нэг өрхөд 2-оос доошгүй ашигтай хүн байлгах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал. Мөн төрийн үйлчилгээний албанд ажиллагсдын сарын дундаж цалинг 120 мянгаас доошгүй хэмжээнд хүргэх, үүний тулд хөдөлмөрийн бүтээмж, цалингийн зохистой харьцааг улам сайжруулж 1 цагийн бүтээмжтэй уялдуулан цалин хөлсний цагийн үнэлгээнд шилжих хэрэгтэй. Өрхийн сарын дундаж хэрэглээг 200 мянган төгрөг байгаа нөхцөлд сарын дундаж орлогыг 220 мянгад хүргэх замаар нэг өрхийн хадгаламж, хуримтлалын тогтвортой өсөлт бий болгох нь шийдвэрлэх асуудлын нэг болоод байна.

Ном зүй

1. “Үнэн” сонин, 2003 оны 4-р сарын 11-ний дугаар
2. Нийт хүн амын 1% нь баян, орлого өндөртэй гэж тооцоолсон байна. “Хүмүүс” сонин, 2003 оны № 13
3. Г. Энхтуяа. “Үнэн” сонин, 2003 оны 11-р сарын 20-ны дугаар
4. “Үнэн” сонин, 2003 оны 11-р сарын 20-ны дугаар
5. “Үнэн” сонин, 2003 оны № 107
6. “Үнэн” сонин, 2003 оны 11-р сарын 20-ны дугаар
7. “Эдийн засаг, онол практик” сэтгүүл, 2001 он, хуудас 65